



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 110

Номгон

Өвөлжилтийн бэлтгэлийг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гал тахиа жилийн зуны дунд сарын сүүлч хүртэл аймгийн хэмжээнд хур тунадас ороогүй, хэт халалт бий болсны улмаас нийт нутгийн хэмжээнд гангийн байдал орж болзошгүй байгаад дүгнэлт хийж, мал сүргийг эрсдлээс хамгаалах, түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар дараах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

1.1. Үүлэнд зориудаар нөлөөлж хур бороо оруулах ажлыг эрчимжүүлж, цаг алдалгүй шуурхай арга хэмжээ авахад мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг чиглүүлсүгэй.

1.2. Зэргэлдээ, хил залгаа аймгийн удирдлагууд, тусгай хамгаалалттай газрын захиргаатай гэрээ, хэлцэл байгуулж, мал оруулж өвөлжүүлэх газар нутгийг тохирч малчдыг оторт нүүлгэх бэлтгэлийг хангуулж ажилласугай.

1.3. Аймгийн хэмжээнд ургамлын гарц бэлчээрийн даацын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсэг томилж, орон нутагтаа болон гадны аймаг, сумдын нутагт өвөлжиж хаваржих малын тоог нарийвчлан тогтоосугай.

1.4. Хадлан бэлтгэх боломжтой аймгуудад хандаж өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдээр гар тэжээл бэлтгүүлэх болзолт уралдаан зарлах, мал сүргээ эрсдлээс хамгаалах боломжит бүхий л арга хэмжээг авч бэлтгэлээ бүрэн базааж ажиллах талаар малчдад зөвлөмж өгч сум, багийн Засаг дарга нарыг удирдлага, зохион байгуулалтаар шуурхай хангаж ажиллахыг үүрэг болгосугай.

1.5. Малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэлэмжийг сайжруулах, мах, түүхий эдийг дотоодын болон гадаадын

0117241

зах зээлд борлуулах, ялангуяа мах экспортлох талаар тодорхой ажил зохион байгуулж Монгол Улсын Засгийн газар, холбогдох яамд, хөрш улс орнууд, мал аж ахуйн бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллахыг зөвлөсүгэй.

1.6. Мал сүргийг эрсдлээс хамгаалах санг нэмэгдүүлэх, байгаль цаг агаар хүндэрсэн тохиолдолд техник, хүн хүчний туслалцаа үзүүлж, хамтран ажиллахыг Зэвсэгт хүчний 339 дүгээр анги, салбар, үйлдвэрлэл үйлчилгээний байгууллага, уул уурхайн компаниудад уриалж тэднийг байнгын бэлэн байдалд байлгаж, дэмжлэгийг авч ажилласугай.

1.7. Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй сумдыг шефийн холбоотой ажиллуулж байсан туршлагыг сэргээж, тухайн сумдаас малын гаралтай бүтээгдэхүүнийг байгууллага, хамт олны хэрэгцээнд нийлүүлэх, цаг хүндэрсэн үед аливаа хэлбэрээр малчдад туслах хөдөлгөөн өрнүүлэх зэрэг нийтийг хамарсан ажлуудыг урьдчилан зохион байгуулахыг зөвлөсүгэй.

2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан зохих шийдвэрүүдийг гаргаж, биелэлтийн явц үр дүнгийн талаар 2017 оны 09 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР